



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 4 сарын 06 өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаал, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цаг агаарын онцгой үзэгдлийн үед Компанийн хэмжээнд галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, тээвэрлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор, "Үер усны идэвхжилтийн үед зам, байгууламжид үзлэг шалгалт хийх, шуурхай ажиллах журам"-ыг нэгдүгээр, "Үзэгдэх орчин хязгаарлагдсан, зам, сум байгууламж элсэнд дарагдсан үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах журам"-ыг хоёрдугаар, "Үер усны идэвхжилтийн үед сонор сэрэмжийн анхаарамж олговол зохих километрүүдийн жагсаалт"-ыг гуравдугаар, "Байгаль цаг агаарын онцгой үзэгдлийн сонор сэрэмжтэй байх, анхаарамж олговол зохих километрүүдийн жагсаалт"-ыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Тушаалыг холбогдох ажилтнуудад танилцуулж, хэрэгжүүлж ажиллахыг Тээврийн удирдлагын газар (Б.Батбаяр)-т, Суурь бүтцийн газар, Тээврийн хяналтын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба (Н.Мөнхсүрэн)-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.БУДБАЯР

ҮЕР УСНЫ ИДЭВХЖИЛТИЙН ҮЕД ЗАМ, БАЙГУУЛАМЖИД ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ХИЙХ, ШУУРХАЙ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, үер усны идэвхжилтийн улиралд цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээлэлд үндэслэн замын байгууламжид үзлэг шалгалтыг шуурхай зохион байгуулж, галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой компанийн нэгжид өгөх үүрэг даалгавар, түүний биелэлтийг хангуулахад оршино.

Хоёр. Зохион байгуулалтын арга хэмжээ

- 2.1. Тээврийн удирдлагын газар болон Суурь бүтцийн газар, Худалдан авах ажиллагааны хэлтэс нь үер усны идэвхжилтийн улиралд урьдчилан сэргийлэх нөөц материалыг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүрдүүлж хяналт тавих, үзлэг шалгалт зохион байгуулах, аюулгүй байдлыг хангаж ажиллах нэгдсэн төлөвлөгөөтэй байна.
- 2.2. “Тавантолгой төмөр зам” ХХК нь Цаг уур, орчны шинжилгээний газар цаашид “ЦУОШГ” гэх газартай мэдээлэл солилцох гэрээ байгуулж, цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээний дагуу Суурь бүтцийн газар түүний харьяа нэгжийн замын диспетчер сэрэмжлүүлэх мэдээллийг нэгдсэн сүлжээгээр хүлээн авч бүх харьяа нэгжийн холбогдох галт тэрэгний диспетчерт дамжуулна.
- 2.3. Салбар нэгжийн диспетчерүүд “ЦУОШГ”-аас ирүүлсэн мэдээг өөр, өөрийн чиглэлээр ээлж ахалж байгаа инженер, техникийн ажилтанд танилцуулж, шаардлагатай тохиолдолд шуурхай тушаал, шийдвэрийн дагуу ажлын нягт уялдаа холбоотой ажиллаж компанийн удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангаж ажиллана
- 2.4. Үер усны идэвхжилтийн үед сонор сэрэмжтэй аялах км-ийн жагсаалтаар сонор сэрэмжийн анхаарамжийг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцэтгэх захирлын тушаалаар олгоно.
- 2.5. Сонор сэрэмжийн анхаарамжтай км-т хур тунадас орсон эсэхийг үл харгалзан төмөр замаар аялах бүх хөдлөх бүрэлдэхүүн зогсоход бэлэн аялна. /Тухайн хэсэгт хур тунадас ороогүй ч алсад орсон үерийн ус орж ирэх эрсдэлтэй /

Гурав. Үзлэг шалгалт зохион байгуулах

- 3.1. Суурь бүтцийн газар, Зам, барилгын хэлтэс нь үер усны идэвхжилтийн үед үерийн эргүүл, хариуцлагатай жижүүр ажиллуулах хуваарь боловсруулж ерөнхий инженерээр батлуулан мөрдөж ажиллана.
- 3.2. Зам, барилгын хэлтсийн диспетчер нь хоорондын замд аялж байгаа галт тэрэгний машинч нартай радио холбоогоор тогтмол холбоотой байж, хоорондын замын байдалд тогтмол хяналт тавьж ажиллана.
- 3.3. Замын хэсэг нь цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээгээр Зам, барилгын хэлтсийн хариуцлагатай жижүүрийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу өдөр

- шөнийн аль ч цагт хуваарийн дагуу эргүүл жижүүрийг томилон ажиллуулна.
- 3.4. Зам, барилгын хэлтсийн үер усны эргүүл нь хоорондын замд хуваарийн дагуу үзлэг шалгалт хийж бороо орж эхлэх цаг, дууссан цаг хугацаа, хур, тунадасны хэмжээний талаарх анхан шатны мэдээллийг Зам, барилгын хэлтсийн диспетчерт технологийн холбоогоор тогтмол өгч мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.
- 3.5. Зам, барилгын хэлтсийн үер усны эргүүл нь хариуцсан хэсэгт нь хур тунадас ороогүй боловч алсад орсон хурын ус голын ай сав, голдирол даган урсан ирэх, үргэлжлэн орсон бороонд зам харгуй хаагдаж үзлэг хийх боломжгүй үед зам, барилгын хэлтсийн диспетчер, хариуцлагатай жижүүрт яаралтай мэдээлэл өгнө. Хариуцлагатай жижүүрийн хуваарийг ээлжийн ахлах гарган хэлтсийн даргаар батлуулна.
- 3.6. Замын хэсгийн мастер, бригадын дарга нь үерийн эргүүлд үзлэгт гарахын өмнө галт тэрэгний хоногийн зурмагийг танилцуулж, өөрийн хэсгээр өнгөрөх галт тэрэгний зурмагтай уялдуулан хаанаас эхлэн үзлэг хийх талаар заавар зөвлөгөөг өгнө.
- 3.7. Аадар бороо орсон үед орон нутгийн онцлог, усанд автаж болзошгүй километрүүдэд нэмэлт эргүүл ажиллуулна.

Дөрөв. Галт тэрэгний диспетчер, өртөөний жижүүр

- 4.1. Галт тэрэгний диспетчер, өртөөний жижүүр нь дараах үүрэгтэй.
- 4.1.1. Зам, барилгын хэлтсийн хариуцлагатай жижүүрийн гаргасан хүсэлтийн дагуу яаралтай тохиолдолд хоорондын замд аялж байгаа галт тэргэнд гэнэтийн анхаарамж олгож хурд бууруулах, шаардлагатай тохиолдолд замын ажилтныг зүтгүүрт суулгаж зам, байгууламжид үзлэг шалгалт хийлгэх.
- 4.1.2. Хоорондын замд автомашинаар явах боломжгүй зам харгуй хаагдсан үед аж ахуйн галт тэргээр зам шалгуулах, ойрхон аж ахуйн галт тэрэг байхгүй үед дан зүтгүүрээр зам шалгах, эсвэл явганаар зам шалгаж дуустал галт тэрэгний хөдөлгөөнийг зогсоох.

Тав. Хоорондын замд аялах зүтгүүрийн бригад

- 5.1. Зүтгүүрийн бригад дараах үүрэгтэй.
- 5.1.1. Замын далангийн хажууд хуримтлагдаж буй ус нь хамгаалалтын далан, суваг шуудууг даваагүй үед хоорондын замд аялж байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг явж болох эсэхийг магадлан, цааш явах боломжтой үед зогсоход бэлэн онц сонор сэрэмжтэй хөдөлгөөнийг үргэлжлүүлж, нөхцөл байдлын тухай ойр байгаа өртөө, зөрлөгийн жижүүрт байнга мэдээлж байна.
- 5.1.1. Замын далангийн хажууд хуримтлагдаж буй ус нь хамгаалалтын далан, суваг шуудууг давсан, үндсэн далангийн 1/2 тэнцүү ирсэн үед галт тэргийг зогсоож замын ажилтныг дуудаж зам шалгаж дуустал зогсох, үзлэг хийж дууссаны дараа явж болно гэсэн шийдвэр гарсан үед тогтоосон хурдтай явж өнгөрөх.
- 5.1.3. Замын үндсэн далан, хамгаалалтын далан, суваг шуудуунд тогтсон усны хэмжээ нь галт тэрэг цааш аялахад аюултай гэж зүтгүүрийн бригад үзвэл галт тэрэгний диспетчерт мэдэгдэн, Хоорондын замыг хаах тухай галт тэрэгний диспетчерээс тушаал өгсний дараа Зам, тээвэр хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тоот тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам"-ын 8 дугаар зүйлийн 8.37-д заасны дагуу явуулсан өртөөндөө ухарч ирэх.

Зургаа. Бусад

- 6.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох ажилтанд компанийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 6.2. Энэхүү журам болон холбогдох дүрэм, стандартыг мөрдөөгүйгээс гарах аливаа хохирол, гологдол, дутагдлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Энэхүү журамд холбогдох газар, хэлтсийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 6.4. Энэхүү журмаар шууд зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

-----o0o-----

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2023 оны 111 дугаар сарын 06 -ны
өдрийн 111 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ҮЗЭГДЭХ ОРЧИН ХЯЗГААРЛАГДСАН, ЗАМ, СУМ БАЙГУУЛАМЖ ЭЛСЭНД ДАРАГДСАН ҮЕД ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Зам, байгууламж элсэнд дарагдсан үед галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллах, цаашид авах шуурхай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахад оршино.

Хоёр. Зохион байгуулалтын арга хэмжээ

- 2.1. Компанийн удирдлага нь дараах үүрэгтэй.
 - 2.1.1. Санхүү, төлөвлөлтийн газар, Худалдан авах ажиллагааны хэлтэс нь замын хэсгүүдэд элстэй тэмцэх гар болон механик багаж, техник хэрэгсэл, нөөц хангалтыг бүрдүүлж өгөх;
 - 2.1.2. Элс дардаг км-ийн судалгааг гаргаж элс даралтын зэргийг тогтоож, байгалийн онцгой үзэгдлийн үед хоорондын замд аялж байгаа хөдлөх бүрэлдэхүүнд сонор сэрэмжийн анхаарамжийг гүйцэтгэх захирлын тушаалаар олгох;
 - 2.1.3. Зам, сум байгууламжийн элс даралтын зэргээс хамаарч анхан, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хөрс судлал, агрохимийн мэргэжлийн эрдэмтэн судлаачтай хамтран боловсруулж төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтыг жил бүрийн төсөвт тогтмол суулгах.

Гурав. Үзэгдэх орчин хязгаарлагдаж, зам, сум байгууламж элсэнд дарагдсан үеийн галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах

- 3.1. Зам, барилгын хэлтсийн диспетчер нь хоорондын замд аялж байгаа галт тэрэгний машинчтай радио холбоогоор харилцан цагийн байдлыг тодруулж Зам, барилгын хэлтсийн инженер, техникийн ажилтан болон хэлтсийн удирдлагыг шуурхай мэдээллээр хангаж ажиллана.
- 3.2. Цаг агаарын онцгой үзэгдлийн үед сонор сэрэмжтэй аялах км-ийн жагсаалтын дагуу тухайн км-т аялж байгаа хөдлөх бүрэлдэхүүн нь зогсоход бэлэн аялна.
- 3.3. Үзэгдэх орчин 100 метрт хязгаарлагдсан, зам байгууламж элсэнд дарагдсан үед хоорондын замд аялж байгаа галт тэрэгнээс бусад бүх галт тэрэгний хөдөлгөөнийг галт тэрэгний диспетчер зогсооно.
- 3.4. Өдөр, шөнийн аль ч цагт хоорондын замд аялж байгаа галт тэрэг нь цаашид аяллаа үргэлжлүүлэх боломжгүй болсон үедээ тусламж дуудна.
- 3.5. Цаг уур, орчны шинжилгээний газар цаашид “ЦУОШГ” гэх газраас ирүүлсэн урьдчилан сэргийлэх мэдээний дагуу цаг агаарын онцгой үзэгдлийн үед зам, барилгын хэлтэс нь мал амьтны нэг түвшний гарцыг түр хугацаагаар хаах бэлтгэлтэй байна.
- 3.6. Зам, сум байгууламж элсэнд дарагдсан үед компанийн хэмжээнд ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилчдыг дайчлан ажиллуулж болно.
- 3.7. Зам, сум байгууламж их хэмжээгээр элсэнд дарагдсан үед “Тавантолгой төмөр зам” ХХК нь Сум, орон нутгийн удирдлага, Онцгой байдлын албанд хүсэлт гаргаж хамтран ажиллана.

Дөрөв. Галт тэрэгний диспетчер

4.1. Галт тэрэгний диспетчер нь дараах үүрэгтэй.

4.1.1. Зам, барилгын хэлтсийн хариуцлагатай жижүүрийн гаргасан хүсэлтийн дагуу яаралтай тохиолдолд хоорондын замд аялж байгаа галт тэргэнд гэнэтийн анхаарамж олгож хурд бууруулах, шаардлагатай тохиолдолд замын ажилтныг зүтгүүрт суулгаж зам, байгууламжид үзлэг шалгалт хийлгэх;

4.1.2. Хоорондын замд автомашинаар явах боломжгүй зам харгуй хаагдсан үед аж ахуйн галт тэргээр зам шалгуулах, ойрхон аж ахуйн галт тэрэг байхгүй үед дан зүтгүүрээр зам шалгах, эсвэл явганаар зам шалгаж дуустал галт тэрэгний хөдөлгөөнийг хаах.

Тав. Хоорондын замд аялах хөдлөх бүрэлдэхүүний бригад

5.1. Хөдлөх бүрэлдэхүүний бригад дараах үүрэгтэй.

5.1.1. Байгалийн гэнэтийн онцгой үзэгдэл болох хүчтэй шороо, цасан шуурга, газар хөдлөлт, үер усны аюул, гал түймрийн улмаас үзэгдэлт 100 метрт хязгаарлагдсан, зам төмөр цас ба элсэнд дарагдсан үед хоорондын замд аялж байгаа хөдлөх бүрэлдэхүүнийг зогсоож явж болох эсэхийг магадлан цааш явах боломжтой үед галт тэрэгний хурдыг 20 км/цаг-аас ихгүй зогсоход бэлэн онц сонор сэрэмжтэй хөдөлгөөнийг үргэлжлүүлж, нөхцөл байдлын тухай ойр байгаа өртөө, зөрлөгийн жижүүрт байнга мэдээлж байна.

Зургаа. Бусад

6.1. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох ажилтанд компанийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Энэхүү журам болон холбогдох дүрэм, стандартыг мөрдөөгүйгээс гарах аливаа хохирол, гологдол, дутагдлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.3. Энэхүү журамд холбогдох газар, хэлтсийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.4. Энэхүү журмаар шууд зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2023 оны 11 дугаар сарын 06 -ны
өдрийн 21/4 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**ҮЕР УСНЫ ИДЭВХЖИЛТИЙН ҮЕД СОНОР СЭРЭМЖИЙН АНХААРАМЖ ОЛГОВОЛ
ЗОХИХ КИЛОМЕТРУУДИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хоорондын зам	Километрүүд
1	Тавантолгой-Цогтцэций	5, 8, 9, 10, 11, 13, 16, 17, 20
2	Тавантолгой өртөө-Ачилтын тойрог 1	1, 4, 5, 7
3	Тавантолгой-Хайрхан	1, 14
4	Хайрхан-Хангай	20, 22, 40, 41, 59
5	Хангай-Урт гол	67, 69, 71, 73, 74, 78, 81, 82, 87, 93, 98
6	Урт гол-Оюут	108, 113, 117, 121, 122, 128, 130
7	Оюут-Шинэ-Ус	148, 165
8	Шинэ-Ус-Хулант	178, 193, 200, 211
9	Хулант-Гашуунсухайт	215, 219, 221, 222

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2023 оны 11 дугаар сарын 06 -ны
өдрийн 8/144 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

**БАЙГАЛЬ ЦАГ АГААРЫН ОНЦГОЙ ҮЗЭГДЛИЙН ҮЕД СОНОР СЭРЭМЖТЭЙ
БАЙХ, АНХААРАМЖ ОЛГОВОЛ ЗОХИХ КИЛОМЕТРУУДИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хоорондын зам	Километрууд
1	Тавантолгой-Цогтцэций	1, 2, 15, 16, 18, 19
2	Тавантолгой өртөө-Ачилтын тойрог 1	1, 2, 3
3	Тавантолгой-Хайрхан	3, 6, 9, 11, 16, 17, 18, 20
4	Хайрхан-Хангай	32, 34, 35, 36, 38, 40, 53, 54, 55, 56, 57, 58, 61
5	Хангай-Урт гол	62, 63, 64, 73, 74, 75, 76, 77, 84, 87, 88, 91, 92, 93
6	Урт гол-Оюут	101, 103, 121, 134, 139, 141
7	Оюут-Шинэ-Ус	145, 146, 147, 148, 149, 150, 155, 158, 160, 162, 166, 167, 168, 170
8	Шинэ-Ус-Хулант	173, 174, 175, 201, 202, 203, 207, 209, 210, 217
9	Хулант-Гашуунсухайт	221

-----oOo-----